

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК-ИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Монложистикс Холдинг ХХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("Хурал")-ыг 2023 оны 11-р сарын 18-ны өдрийн 14.00-15:40 цагт Facebook хуудас ашиглан цахимаар хуралдуулав. Хурлын шууд дамжуулалтыг Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Самбүүгийн гудамж 2, Бльюмон Төв, 10 давхарт Хурлын ирц бүртгэл болон санал хураалтыг Мандал Капитал Маркетс ХХК-ийн хөгжүүлсэн программ хангамжийг ашиглан явуулав.

Хурлын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал Г.Хишигбат, Хурлын Тооллогын комиссоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн дотоод аудитор Б.Тамжиддорж (дарга), санхүүгийн шинжээч Б.Амарбаясгалан, ахлах нягтлан бодогч Э.Хишигтогтох нар, Хурал зохион байгуулах комиссоор Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Нарангарвуу (дарга), үйл ажиллагаа эрхэлсэн захирал Б.Азжаргал, хуульч Х.Хишигжаргал, Маркетингийн менежер М.Хосбаяр нар тус тус ажиллав.

Хурал зохион байгуулах комиссын дарга Хурлын дэгийг танилцуулж, Тооллогын комиссын даргаас хурлын ирцийг танилцуулахыг хүсэв. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргахад нийт хуралд оролцох эрхтэй 395,858,822 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 1336 хувьцаа эзэмшигч байснаас хуралд 342,778,698 ширхэг энгийн хувьцаа бүхий 65 хувьцаа эзэмшигч оролцож, хурлын ирц 86.59 хувиар хүчин төгөлдөр болж байгааг Хурлын даргад мэдээлэв.

Монложистикс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Хурлын дарга Г.Хишигбат хурлыг нээж үг хэлэв.

Хурлаар хэлэлцэх асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулав. Үүнд:

- (i) Компанийн Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн, батлах
- (ii) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох
- (iii) ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг батлах
- (iv) Гол ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу опцион гаргахад зөвшөөрөл олгох

Хурал зохион байгуулах комиссын дарга хэлэлцэх асуудал тус бүрээр танилцуулахыг Хурлын даргаас хүсэв.

1. КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭН, БАТЛАХ

Компани хувьцаагаа олон нийтэд санал болгох ажлын хүрээнд Компанийн дүрмийн найруулгын анхны төслийг Компанийн хуулийн хэлтэс боловсруулсан бөгөөд "Хаанлекс Партнерс" ХХН нь уг төсөл дээр дүгнэлт гаргаж, 2023 оны 5-р сарын 08-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлаар Компанийн дүрмийн найруулгын төсөл болон үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулгыг батламжлуулсан тухай дурдаад Компанийн Дүрмийн онцлох дараах зохицуулалтуудыг Хурлын дарга танилцуулав. Үүнд:

КОМПАНИЙН ДҮРЭМ НЬ ДАРААХ АГУУЛГА БҮХИЙ НИЙТ 16 БҮЛЭГТЭЙ.

1. Нийлэг үндэслэл
2. Компанийн эрх зүйн байдал
3. Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл
4. Компанийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө
5. Компанийн удирдлага, хувьцаа эзэмшигч
6. Хувьцаа эзэмшигчдийн хурал
7. Төлөөлөн удирдах зөвлөл
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод
9. Компанийн эрх бүхий албан тушаалтан
10. Компанийн хяналтын тогтолцоо
11. Компанийн үнэт цаасыг гаргах, худалдах, эргүүлэх авах
12. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан
13. Ногдол ашиг
14. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл
15. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах
16. Дүрэм хүчин төгөлдөр болох

ДҮРЭМД ӨӨРӨӨР ЗААСАН БҮЮУ ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТУУД

1. Компанийн үндсэн зорилго- Тээвэр, ложистикийн салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулах, бизнесийн олон талт, мэргэжлийн зөвлөгөө өгөх замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал /Зургаадугаар бүлэг/

❖ Хурлын ирц

Компанийн тухай хуульд:	Компанийн дүрмийн төсөлд:
Саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛДОГ БОЛ	ХЭХ-д компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны <u>дийлэнх олонх (66.67%)</u> болон түүнээс дээш хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болохоор зохицуулсан. /Компанийн дүрмийн 6.8/

3. Төлөөлөн удирдах зөвлөл /Долдугаар бүлэг/
 - ❖ Бүтэц, бүрэлдэхүүн- Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхыг хараат бус гишүүн байлгахыг зорино. /Компанийн дүрмийн 7.4/
 - ❖ Бүрэн эрхийн хугацаа- ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацааг жил байхаар тогтоосон. /Компанийн дүрмийн 7.5/
 - ❖ Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийн хуваарилалт- ТУЗ батлах /Компанийн дүрмийн 7.14.16/
4. Охин компанитай холбоотой эрх хэмжээ / Компанийн дүрмийн 7.14.22- 7.14.25/
 - 4.1. Компанийн 100 хувийн охин компанид хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Толгой компани буюу “Монложистикс Холдинг” ХК-ийн ТУЗ хэрэгжүүлэх
 - 4.2. Компанийн 100 хувийн охин компанийн ногдол ашиг тараах эсэх шийдвэрийг хувьцаа эзэмшигч буюу “Монложистикс Холдинг” ХК-ийн ТУЗ гаргах
 - 4.3. Компанийн 100 хувийн охин компанид сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох
5. Компанийн дүрмээр опцион гаргахыг зөвшөөрсөн- Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах, худалдах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болох ба тухайн асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. /Компанийн дүрмийн 11.4/

2. КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ КУМУЛЯТИВ АРГААР СОНГОХ

Компанийн Дүрмийн төсөлд заасны дагуу, мөн хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхээр ирүүлсэн санал, ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2023 оны 9-р сарын 27-ны өдрийн 23/НДБЦУХ/01 тоот дүгнэлтийг үндэслэн Лувсанжамба овогтой Ганзоригт, Бааст овогтой Тэлэнгэд, Ганзоригт овогтой Хишигбат, Балдан овогтой Энхтүвшин, Өлзийбаяр овогтой Ганзориг нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнд, Санжаа овогтой Сайнбат, Эрэндоо овогтой Оюунбилэг, Готов овогтой Цэрэнпүрэв, Сэнгээ овогтой Энх-Амгалан, Гарамдорж овогтой Гантулга нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнд тус тус нэр дэвшүүлж байгаа тухай дурдаад ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг Хурлын дарга танилцуулав.

3. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ

Компанийн Дүрмийн төсөлд заасны дагуу Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг Хурлаар хэлэлцүүлж батлуулах тухай 2024 оны Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх нийт 102,5 сая төгрөгийн ТУЗ-ийн төсвийн саналыг дараах төсвийн саналын задаргааг Хурлын дарга танилцуулав: Үүнд:

1. ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитор цалин урамшуулал - 99,5 сая төгрөг;
2. ТУЗ-ийн хурал – 2 сая төгрөг;
3. Бичиг хэрэг болон бусад – 1 сая төгрөг.

4. ГОЛ АЖИЛТНУУДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ ОПЦИОН ГАРГАХАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

Компани нь хүний нөөцийн тогтвортой байдал, ажилтан болон хувьцаа эзэмшигч нарын ашиг сонирхлыг нэгтгэх зорилгоор үндсэн хоёр хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс Key Employee Stock Option буюу “KESO” хөтөлбөрийн зорилго нь хувьцаа эзэмшигч болон гол ажилтнуудад хоорондын ашиг сонирхлыг нэгтгэх, менежментийн ажилтнуудын тогтвортой байдлыг хангах, ажилтнуудад урт хугацааны хүримтлалыг бий болгох зорилгоор 5+ зэргийн хувьцаа эзэмшигчид бус ажилтнууд буюу группийн хэмжээнд менежер болон түүнээс дээш зэргийн нийт 30 ажилтан тус хөтөлбөрт хамрагдах тухай хэлэв. Компани ирээдүйд эргүүлэн худалдан авах 7,320,000 ширхэг энгийн хувьцаа буюу нийт Компанийн ойролцоогоор 1.85 хувийг гол ажилтнуудад опцион хэлбэрээр 4 жилийн хугацаатайгаар буюу жил бүр 25 хувь эзэмших эрх нээгдэх нөхцөлөөр эзэмшүүлэхээр төлөвлөж байгаа болон Компани шинээр хувьцаа гаргах эсхүл зарлахгүй бөгөөд Компани 7,320,000 ширхэг бүхий энгийн хувьцааг эргүүлэн худалдан авах тухай дахин онцлоод, мөн опционы тоо, үнэ, хугацаа, хэрэгжүүлэх нөхцөл зэргийг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх тухай, худалдан авах үнэ нь хуулийн дагуу опцион гаргахаас өмнөх сүүлийн нэг сарын арилжааны жигнэсэн дундаж ханшаас доошгүй байх зохицуулалттай тухай хэлээд, энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх шийдвэрийн дагуу нийт хувьцаа эзэмшигчид тухайн энгийн хувьцаанд хөрвөх опционыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэх тухай Хурлын дарга танилцуулав.

Хурал зохион байгуулах комиссын дарга хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс ирүүлсэн асуултыг багцлан асууж, Компанийн Гүйцэтгэх захирал холбогдох хариултыг өгөв.

Асуулт 1: Опцион хувьцааны ханшид хэрхэн нөлөөлөх вэ?

Хариулт: Гол ажилтнуудад эзэмшүүлэх опцион нь хувьцааны ханшид нөлөөлөхгүй болно. Опцион гэрээний зохицуулалт нь урт хугацаанд буюу 4 жилийн хугацаанд 25 хувиар эрх нээгдэх, мөн эрх нээгдсэний дараа 6 сарын хугацаанд хувьцаа нь түгжигдэх нөхцөлтэй байгаа тул хувьцааны ханшид нөлөөлөл байхгүй гэж үзэж байна.

Асуулт 2: Танайх өөрийн эзэмшлийн вагоноо худалдан авсан уу. Аваагүй бол процессын хувьд хэрхэн явж байгаа вэ?

Хариулт: Компани IPO хийх ажлын хүрээнд үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулга дээр олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн дийлэнхийг вагон худалдан авах зарцуулна гэж төлөвлөсөн. Үүний дагуу 2023 оны 9 сард IPO болсны дараа хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулсан мөнгө Компанид шилжин орж ирснээр вагон худалдан авах процесс эхэлсэн бөгөөд өндөр үнийн дүнтэй худалдан авалт тул худалдан авалтыг боловсронгуй хэмжээнд гүйцэтгэх үүднээс олон оролцогч талууд болох үйлдвэрлэгч, агентууд, хуулийн фирм, зээлдүүлэгч, техникийн эксперт зөвлөх гээд гаднын 5 компаниудыг оролцуулан ажил явж байна. 2024 оны эхний улиралд вагон худалдан авсан байхаар төлөвлөж байгаа тухай хэлэв.

Асуулт 3: Хувьцаа ханш яагаад унасан вэ?

Хариулт: Компанийн хувьцааны ханш IPO хийснээс хойш бага зэрэг уналт үзүүлсэн нь МУ-ын хөрөнгийн зах зээл уналттай байна. Мөн өнгөрсөн хугацаанд Компанийн IPO-р богино хугацаанд хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчид нь өөрсдийн хувьцааг зараад гарсан. Энэхүү Компанийн хувьцааны уналт нь Компанийн үйл ажиллагаатай уялдаагүй бөгөөд нийт Компанийн ачаа тээвэр 171 хувиар өссөн, нийт орлого 50 орчим хувиар өссөн. Компани нь өөрийн стратегийг маш амжилттай хэрэгжүүлж байна. Цаашид урт хугацаандаа хувьцааны ханш Компанийн суурь үзүүлэлттэйгээ уялдаад явах тухай хэлэв.

Асуулт 4: Тээврийн тоо 171%-р унасан боловч орлого яагаад 47%-р өссөн вэ?

Хариулт: Компани 10 сард Группийн 3-р улирлын үйл ажиллагааны тайланг олон нийтэд нийтэлсэн. Нийт тээвэрлэсэн ачааны тоо хэмжээ 171%-р өссөн, нөгөө талдаа орлого 47%-р өссөн байгаа. Хоёр үндсэн суурь шалтгааны нэг нь ачаа тээврийн дийлэнх өсөлтийг Монгол улсаар дамжин өнгөрч байгаа Транзит тээвэр бүрдүүлсэн бөгөөд Монложистикс Транзит компани 300 хувийн өсөлт үзүүлсэн. Транзитын орлого нь импортын орлоготой харьцуулахад нэгж тээвэр дээр харьцангуй бага байдаг тул орлогын хэмжээ нь ачааны тоо хэмжээтэй харьцаж өсөж чадаагүй. 2-р суурь шалтгаан нь Ковид-ын дараа дэлхий нийтээрээ тээвэр ложистикийн доголдол бий болсонтой холбоотой тээвэр ложистикийн зардал өссөн. Энэхүү өсөлт нь энэ жилийн хувьд буцаж буусан учраас манай импортын бизнес болох Монложистикс Ворлдвайд компанийн үйл ажиллагааны орлого нь нэгж тээврийн тоо ширхэгээрээ бууснаар орлогын өсөлт болон ачаа тээврийн өсөлттэй 100 хувь уялдаж чадаагүй тухай хэлэв.

Асуулт 5: 2024 оныг хэрхэн харж байгаа вэ?

Хариулт: Өнгөрсөн 7 хоногт Монложистикс групп нь ТУЗ-өөр ирэх онын стратеги төлөвлөгөө, төсөв, орон тоо бизнес төлөвлөгөөгөө батлуулсан. Ирэх жилийг өөдрөгөөр харж байгаа нэг талаасаа Монгол улсын эдийн засаг давгүй өсөлттэй байна гэж харж байна. Монгол улс болон Хятад улсын эдийн засгийн өсөлтийг үзүүлдэг түүхий эдийн үнэ харьцангуй тогтвортой байна. Улсын Их хурал дээр батлагдсан улсын төсөв өнгөрсөн жилээс өндөр өсөлттэй том хэмжээний төсөв батлагдлаа. Дээрх хүчин зүйлс эдийн засгийн өсөлтийг үзүүлнэ гэж харж байна. Монложистикс групп нь ирэх жил өндөр өсөлт төлөвлөж, өөрсдийн вагон орж ирэхээр манай түүхий эдийн экспортын үйл ажиллагаа эрчимжинэ гэж харж байна.

Асуулт 6: 2024 оныг хэрхэн харж байгаа вэ?

Хариулт: Опцион гэдэг нь компани болон ажилтан хоорондын байгуулсан гэрээ юм. Ажилтан тухайн гэрээн дээр заасан тоо хэмжээний хувьцааг худалдан авах эрх үүсэх, уг эрхийг зохицуулж байгаа гэрээ юм. Дээрх хөтөлбөр нь олон улсад ашиглагддаг арга хэрэгсэл бөгөөд нэг талаасаа Компанийн гол ажилтнуудыг компанийн амжилттай үялдуулах, нөгөө талаасаа тухайн ажилтнуудад урт хугацааны хуримтлалтай болох боломжийг олгож байгаа чухал хөтөлбөр юм.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудалтай холбоотой санал хураалт эхэлж, санал өгөх хугацаа 15 мин үргэлжлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Тооллогын комиссыг Хурлын санал хураалтын дүнг танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга Хурлын санал хураалтын дүнг дараах байдлаар Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд мэдээлэв. Үүнд:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн, батлах:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
337,969,400	100%	0	0%	0	0%
Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.7-д заасны дагуу шийдвэр 100 хувиар хүчинтэй.					

2. Компанийн түз-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох:

Утга	Нэр дэвшигчдийн нэрс	Нийт хувьцаа эзэмшигчдийн өгсөн санал		Сонгогдсон эсэх
		Тоо	Хувь	
Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай	Ердийн гишүүнд нэр дэвшигч:			
	1. Лувсанжамбын Ганзоригт	394,797,222	12.98%	Тийм
	2. Баастын Тэлэнгэд	393,845,558	12.95%	Тийм
	3. Ганзоригтын Хишигбат	375,163,269	12.33%	Тийм
	4. Өлзийбаярын Ганзориг	294,048,891	9.67%	Тийм

5. Балдангийн Энхтүвшин	287,508,133	9.45%	Тийм
Хараат бус гишүүнд нэр дэвшигч:			
6. Гарамдоржийн Гантулга	137,143,762	4.51%	Үгүй
7. Готовын Цэрэнпүрэв	288,146,133	9.47%	Тийм
8. Эрэндоогийн Оюунбилэг	291,951,012	9.60%	Тийм
9. Санжаагийн Сайнбат	291,446,533	9.58%	Тийм
10. Сэнгээгийн Энх-Амгалан	287,454,316	9.45%	Тийм

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д тус тус заасны дагуу тооллогоор хамгийн өндөр саналын эрх авсан нэр дэвшигчдийг сонгосон ба шийдвэр хүчинтэй.

3. ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг батлах:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
337,948,207	100%	80	0%	0	0%

Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5-д заасны дагуу шийдвэр 100 хувиар хүчинтэй.

4. Гол ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу опцион гаргахад зөвшөөрөл олгох тухай:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
330,710,045	98.37%	5,465,380	1.63%	4	0%

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5-д заасны дагуу шийдвэр 98.37 хувиар хүчинтэй.

Хурлын дарга санал хураалтын дүнтэй танилцаад хурлаас дараах шийдвэрүүд гарсан тухай танилцулав. Үүнд:

Шийдвэр 1: Компанийн дүрмийн төслийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Монложистикс Холдинг ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ШИЙДВЭРЛЭХ НЬ:

- “Монложистикс Холдинг” хувьцаат компанийн дүрмийн төсөл (“Дүрэм”)-ийг хавсралтаар баталсугай.
- Компанийн Дүрмийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар бүртгүүлэх болон шаардлагатай баримт бичиг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх

байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Нарангарвуу/-д даалгасугай.

3. Компанийн Дүрмийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Хишигбат)-д үүрэг болгосугай.

Шийдвэр 2: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дэх заалт, Монложистикс Холдинг ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн ердийн гишүүдээр дор дурдсан хамгийн өндөр саналын эрх авсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - 1.1. Лувсанжамбын Ганзоригт,
 - 1.2. Баастын Тэлэнгэд,
 - 1.3. Ганзоригтын Хишигбат,
 - 1.4. Балдангийн Энхтүвшин,
 - 1.5. Өлзийбаярын Ганзориг,
2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр дор дурдсан хамгийн өндөр саналын эрх авсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - 2.1. Санжаагийн Сайнбат,
 - 2.2. Эрэндоогийн Оюунбилэг,
 - 2.3. Готовын Цэрэнпүрэв,
 - 2.4. Сэнгээгийн Энх-Амгалан,
3. Энэхүү шийдвэр гарсантай холбоотойгоор өмнөх ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь чөлөөлсүгэй.
4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Хишигбат)-д үүрэг болгосугай.

Шийдвэр 3: Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, 62.1.15 дахь заалт, "Монложистикс Холдинг" ХХК /цаашид "Компани" гэх/-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг дараах байдлаар баталсугай.

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төгрөг/
-----	---------------	----------------------

1	ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитор цалин урамшуулал	99,500,000
2	ТУЗ-ийн хурал	2,000,000
3	Бичиг хэрэг болон бусад	1,000,000
Дүн		102,500,000

- Энэхүү шийдвэрийг болон шаардлагатай баримт бичиг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Нарангарвуу/-д даалгасугай.
- Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Компанийн гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д үүрэг болгосугай.

Шийдвэр 4: Гол ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд опцион гаргах зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь заалт, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.8, 62.1.15 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь заалт, “Монложистикс Холдинг” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ШИЙДВЭРЛЭХ НЬ:

- Компанийн гол ажилтнуудыг урамшуулах зорилгоор энгийн хувьцаанд суурилсан, компанийн хувьцааг худалдан авч болох эрхийг баталгаажуулсан опцион гаргахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.
- Дээрх хөтөлбөрийн хүрээнд Компаниас гарах үнэт цаас буюу опционыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ Хувьцаа эзэмшигчид нь хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
- Энэхүү шийдвэрийг болон шаардлагатай баримт бичиг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Нарангарвуу/-д даалгасугай.
- Тус шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Компанийн гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д үүрэг болгосугай.

Хурлын Дарга Хурлыг хаав.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХИШИГБАТ